

ОРЧИН ҮЕИЙН ОРОС - АМЕРИКИЙН ХАРИЛЦАА: ХЯЗГААРЛАГДМАЛ ТҮНШЛЭЛ

А.Нямдолжин¹

Дэлхийн нөлөө бүхий хоёр их гүрэн болох Орос, Америкийн улс төрийн тавцан дахь бодлого, шийдвэр, тэдний хоорондын харилцаанаас дэлхийн дэг журам, олон улсын харилцааны чиг хандлага, хүчний тэнцвэрт байдал шууд хамаарсаар ирсэн.

“Хүйтэн дайны” үед дэлхийн их гүрнүүдийн цэрэг улс төрийн эвсэл, капитализм, социализм гэсэн нийгэм-эдийн засгийн байгуулал, үзэл суртлын ялгаатай байдал нь улс орнуудыг хоёр өөр ертөнцөд талцуулан хувааж, дэлхийн II дайнд фашизмын эсрэг холбоотон болж явсан ЗХУ, АНУ тэргүүтэй их гүрнүүд бусдыгаа тойруулан нягтарч, нэг нэгнийхээ өөдөөс сөрөн зогсож, улмаар зэвсэглэлээр улайран хөөцөлдөн уралдсаар хурцадмал байдал даамжирч, цөмийн дайны ирмэгт тулж ирээд байв. Энэ үед дэлхийн хоёр туйлт тогтолцооны нэг болох ЗХУ задран унаж, “хүйтэн дайны” үе төгсгөл болсоны үр дүнд дэлхийн II дайнаас хойш бүрэлдэн тогтсон олон улсын харилцааны систем, эвлэршгүй хэв шинж өөрчлөгдөж, бүх нийтийн болон цөмийн дайны болзошгүй аюул, заналын магадлал эрс буурсан.

Хоёр том эвслийн тэмцэл, сөргөлдөөн төгсгөл болж, дэлхийн дэг журамд олон улсын эрх зүйд суурилсан харилцааны үндсэн дээр улс хоорондын дайн, зэвсэгт мөргөлдөөн зогсож, тогтвортой байдал бүрэлдэн, аюулгүй байдлын асуудал бүрэн шийдвэрлэгдэн, энх

¹ ШУА-ийн ОУХХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Ph.D, ЭШТА

тайван бүрэлдэн тогтоно гэсэн дэлхий нийтийн найдлага төдийлөн биелсэнгүй. Харин дэлхийн болон бүс нутгийн тогтвортой байдал, энх тайван, аюулгүй байдалд хор хохирол учруулах угсаатан үндэстэн, шашин, түүний урсгалуудын хоорондын мөргөлдөөн үргэлжлэхийн зэрэгцээ олон улсын терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, дүрвэгсдийн асуудал, санхүү, хөрөнгийн зах зээлийн хямрал, ядуурал, халдварт өвчний тархалт, эрчим хүчний хомсдол, байгаль, экологийн асуудал, дэлхийн цаг уурын дулаарал зэрэг уламжлалт бус аюул занал даяар шинжтэй болж, тэдгээрийн хор уршиг нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаагийн дээр хүн төрөлхтөний эрүүл, аюулгүй орчинд айх аюулгүй амьдрахад нөлөөлж буй эрсдэл, аюулын хамрах хүрээ улам тэлсээр байна.

Даяарчлалыг хамарсан эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд Орос, Америк хоёр их гүрний оролцоонд тулгуурлан хамтын хүчин чармайлтаа бэхжүүлэх шаардлага аяндаа урган гарч, олон улсын аюулгүй байдлыг хангах хамтын ажиллагааны талбарыг зүй ёсоор бий болгож байна.

Орос-Америкийн хооронд стратегийн түвшиний түншлэлийн харилцааг тунхагласан хэдий ч уламжлалт болон эдийн засгийн ашиг сонирхол, хоёр туйлт харилцаанд далдлагдаж байсан зөрчил ил гарч, хоёр орны харилцаа нэг ойртож, нэг хөндийрсөөр хязгаарлагдмал шинжтэй стратегийн түншлэл бүхий “хүйтэн хэлбэрийн” харилцаа хэмээн тодорхойлох хэмжээнд хүрчээ. Орос-Америкийн харилцаа ээдрээ, төвөгтэй үе шатуудыг туулах явцад олон улсын харилцааны хэмжээнд тус тусын ашиг сонирхолд хөтлөгдөх хэв шинжийг агуулсаар ирсэн.

1. Орос, Америкийн харилцааны хувьсал

ОХУ коммунист үзэл баримтлалаас татгалзаж, ардчилсан хөгжлийн замыг сонгон улс төр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлт, шилжилтийн хүнд хямралын үеийг даван туулж зах зээлийн, нээлттэй эдийн засгийн замаар хөгжиж байна. Өнөөгийн олон улсын харилцааны системд өөрийгөө тодорхойлох хангалттай хүч, асар их нөөц, байгалийн баялаг, цөмийн зэвсэг зэрэг хүчин зүйлсийг ЗХУ-аас өвлөн авсан ОХУ дэлхийн хэмжээний гүрний байр

сууриа дахин сэргээхийг эрмэлзэж байна. Гэвч Зөвлөлтийн үетэй харьцуулахад өнөөгийн ОХУ геополитикийн хувьд тун таагүй, гадаад эдийн засгийн интеграцид өрсөлдөх хэмжээний эдийн засгийн чадавхи сул, хувьсан өөрчлөгдөж буй дэлхийн орчин нөхцөлд дасан зохицох, өөрчлөлт болгоныг хүлээж авах бэлтгэл дутмагийн улмаас хүндрэл бэрхшээлүүдтэй нүүр тулсаар байна.

Харин дэлхийн шинэхэн түүхийн энэ хувьсалын үр дүнд ЗХУ задран унаснаар АНУ-ын эсрэг баттай зогсох гүрэн байхгүй болж, олон улсын тавцанд дангаараа хэт их гүрэн хэвээр үлдсэн ба Америк төвтэй “нэг туйлт” дэлхийн цор ганц тэргүүлэх гүрэн болон хувирсан билээ. АНУ цэргийн хүчин чадал, эдийн засаг, шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологийн хөгжлийн чадавхиараа дэлхийд тэргүүлж, улмаар дэлхийн улс төрийн нөхцөл байдалд хүчтэй нөлөөлөх хүчин зүйлсийг бүрдүүлж чадсан юм. Үүнд 1992-2001 оны хооронд америкийн эдийн засгийн ер бусын өсөлтийн (ДНБ 77%-д хүрсэн) үе ч чухал нөлөө үзүүлсэн бөгөөд дэлхийн эдийн засгийн гуравны нэг хувь АНУ-д оногдож байна. Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Дэлхийн худалдааны байгууллага зэрэг олон улсын санхүү, эдийн засгийн төвүүдийн үйл ажиллагаанд давамгайлах үүрэгтэй оролцож, олон улсын тавцан дээр удирдах байр суурийг эзлэн “тоглоомын дүрмийг” тодорхойлох болов. ОХУ ч үүнтэй зэрэгцэн БРИКС, ШХАБ, ЕАЭЗХ байгуулах замаар өөрийн нөлөөний хүрээгээ тэлэн, олон улсын тавцанд байр сууриа бэхжүүлэхийг зорьж байна.

ОХУ 1990-ээд онд бий болсон геополитик, олон улсын стратегийн шинэ нөхцөл байдал хийгээд АНУ-ын манлайлал хэт үүсч, олон улсын хэмжээний аливаа асуудлыг шийдэхэд АНУ дангаар үүрэг гүйцэтгэж, өөрийн байр сууриа тулгаж байгааг эсэргүүцэн дэлхийн дэг журмын шилжилтийн энэ үед олон туйлт ертөнцийг бий болгоход анхаарлаа хандуулж эхэлсэн. Тухайлбал, ОХУ, БНХАУ-ын хооронд 1997 онд байгуулсан Олон улсын шинэ дэг журам төлөвшүүлэх ба олон туйлт ертөнцийн талаарх хамтарсан мэдэгдэл гаргасан нь АНУ-ын хэт манлайллыг сааруулах, хүчний харьцааг тэнцүүлэх бодлого тэдний хоорондын харилцаанд идэвхижиж, стратегийн ашиг сонирхол нийлж, нөлөөллийн бүсэд аюулгүй байдлын загваруудыг үүсгэх арга замыг эрэлхийлэх болсоны нэг илрэл юм.

1.1. Орос, Америкийн ойртох эхний алхам (1991-1999 он)

1990-ээд оны Орос, Америкийн харилцаа нь “хүйтэн дайны” үеийн улс төр, эдийн засаг, үзэл суртлын гүн хямралыг арилгахад чиглэж байв. Юуны өмнө тэр үеийн цөмийн зэвсгийн 90 гаруй хувь зөвхөн Орос, Америкийн хуримтлуулсан зэвсэг байсан ба тэр нь өөрсдийг нь төдийгүй дэлхийг тэр чигээр нь хэд дахин устгах хэмжээнд хүртэлээ хуримтлагдсан байв. Тийм ч учраас стратегийн ач холбогдолтой цөмийн зэвсэг эзэмшигч Орос, Америкийн түншлэлийн харилцаа нь олон улсын энх тайван, тогтвортой, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд туйлын чухал байв. Орос, Америкийн төрийн тэргүүнүүд 1991, 1992 онд байгуулсан стратегийн давшилтын зэвсэг хорогдуулах (СНВ-1), (СНВ-2) гэрээний хүрээнд үй олноор хөнөөх зэвсгийг үл дэлгэрүүлэх, устгах, хураах, зэвсгийн тоо, хэмжээг бууруулахад чиглэсэн алхмууд хийв. Хоёр орны шинэ үеийн харилцааны үндэс суурь болсон олон чухал баримт бичгүүдийг батлан гаргав. Оросын ерөнхийлөгч Б.Н.Ельцин, Америкийн ерөнхийлөгч том Дж.Буш нар 1992 оны 2-р сарын Кэмп-Дэвидын тунхаглалаар “Хүйтэн дайн” дууссаныг албан ёсоор зарлаж, Орос-Америкийн харилцааны шинэ хэлбэрийн харилцааны үндэсийг тавьсан.

1992 оны 6-р сарын Вашингтоны “Орос-Америкийн найрамдал, түншлэлийн Харти” -д хоёр орны ерөнхийлөгчид гарын үсэг зурав. Тус хартид “Ванкуверээс Владивосток хүртэл аюулгүй байдлын нэгдсэн систем” байгуулахаа зарлаж, 1993 оны 4-р сарын Ванкуверын тунхаглалаар Орос, Америкийн хооронд стратегийн түншлэлийг тунхагласан².

НАТО Төв, Зүүн Европ, Балканы хойгийн орнуудыг эгнээндээ нэгтгээд ОХУ-ын хил рүү хурдацтайгаар хүрээгээ тэлэх болсон, АНУ-ын ТУХН-ийн орнуудын талаар явуулж буй бодлого, АНУ-ын зүгээс Чечень дэх Оросын явуулж буй цэрэг дайны үйл ажиллагааг шүүмжилсэн, Оросын дотоод хэрэгт АНУ хөндлөнгөөс оролцож байна гэх зэрэг зөрчил хоёр орны харилцаанд хуримтлагдсаар 1990-ээд оны сүүл гэхэд Орос, Америкийн харилцаа саарахад хүргэлээ.

2 "Vancouver Declaration". First Clinton-Yeltsin summit, Vancouver, Canada. 3-4 April 1993. <http://www.bits.de/NRANEU/US-Russia/A%20Official%20Docs/Clint%20Yelt%201st%20sum%20dec%20exc.htm>

1.2. Орос, Америкийн ойртох хоёр дахь алхам (2001-2008 он)

Жил хагасын дараахнаас Орос-Америкийн харилцаа дахин сэргэв. 2001 оны 9-р сарын 11-ны халдлага Орос, Америк хоёрыг ойртуулсан ховор тохиол байв. Учир нь дэлхийн хэмжээний терроризмын аюул занал, үй олноор хөнөөх зэвсэг тархах явдлыг бууруулахад Орос, Америк хоёрт хамтын ажиллагаагаа өрнүүлэх шаардлага бий болж алан хядах ажиллагааны эсрэг хамтдаа сөрөн зогсох шинэ сорилт тулгарав. Халдлагын дараа 2001-2002 оны босгон дээр АНУ Афганистанд явуулсан терроризмын эсрэг ажиллагаа Оросын төдийгүй дэлхийн нийгэмлэгийн зүгээс тодорхой хэмжээний дэмжлэг авч чадсан юм. 2002 онд 5-р сард хоёр их гүрний төрийн тэргүүн нар Москвагийн шинэ стратегийн түншлэлийн тухай тунхаглалыг байгуулав. Тус тунхаглалын хүрээнд стратегийн давшилтын зэвсэг хорогдуулах тухай (СНВ-2) гэрээ байгуулсан явдал хоёр орны итгэлцэл, нээлттэй байдлыг хангах гол үндэс суурь болно хэмээн талууд үзэж байлаа. Гэвч АНУ Англи болон Греландын нутаг дэвсгэр дээр пуужингийн довтолгооноос хамгаалах (ПДХ) систем байрлуулж, улмаар Иран болон Хойд Солонгосын болзошгүй цөмийн аюулаас хамгаалах хамгаалалтын системийг хөгжүүлэх шаардлагатай хэмээн үзсэн учир 1997 оны ПДХ системийг хязгаарлах тухай³ Нью-Йоркийн гэрээнээс гарсан нь дээрх Москвагийн тунхаглалыг зөрчсөн явдал бөгөөд нэгэнт тогтсон хүчний тэнцвэрийг алдагдуулж байна хэмээн Оросын тал үзэв. Ийнхүү 15 жилийн турш Орос-Америкийн хооронд тогтсон цөмийн тэнцвэрт байдал алдагдсанаар хоёр орны харилцаанд таагүй уур амьсгалыг бий болгов.

2007 оны 2-р сарын 10-нд Мюнхены олон улсын аюулгүй байдлын хурал дээр Оросын Ерөнхийлөгч В.Путины тавьсан илтгэлд АНУ болон Бушийн жанжин шугамыг эрс шүүмжлэн, нэг улс орны эрх баригчид, тэр дундаа АНУ-ын эдийн засаг, улс төр, хүмүүнлэгийн бүх салбарт эрх үүргээ хэтрүүлэн ашиглаж, өөрсдийн үзэл бодлоо бусад улс оронд тулган хүлээлгэж байна. Аливаа асуудлыг НАТО-ийн хүрээнд авч үзэлгүй, Орос болон БРИКС-ийн гишүүн улс орнуудын санал бодлыг

³ 1997 оны 9-р сарын 26-нд талууд ЗХУ, АНУ-ын хооронд 1972 оны 5-р сарын 26-ны пуужингийн довтолгооноос хамгаалах системийг хязгаарлах тухай гэрээтэй холбогдуулан тохиролцох санамж бичигт гарын үсэг зурсан.

харгалзан үзсэн аюулгүй ажиллагааны шинэ тогтолцоог бүрдүүлэх санал гаргасан. Эцэст нь АНУ Польш, Чехийн нутаг дэвсгэр дээр ПДХ систем байгуулан НАТО-г зүүн тийш өргөжүүлэх төлөвлөгөөнөөсөө татгалзахгүй бол Москва цэргийн хариу арга хэмжээ авах болно⁴ гэдгээ мэдэгдсэнээр Орос, Америкийн харилцаа муудав. Орост цэрэг улс төрийн шахалт үзүүлэх үүднээс НАТО-г зүүн тийш тэлж, цэргийн ажиллагаа, оролцоогоо их хэмжээгээр идэвхжүүлж, ПДХ системийн байршлын шинэ бүс байгуулах явдлыг Орос эрс эсэргүүцдэг. Орос 2008 оны 8-р сарын Өмнөд Осетийг тойрсон үйл явдал буюу Орос, Гүржийн хоорондох “таван өдрийн дайн”-ы үр дүнд Орос, Америкийн харилцаа хүйтэн дайны түвшинд хүртлээ муудав. Учир нь тус дайнаар хөшүүрэг болгон хуучин зөвлөлтийн нутаг дэвсгэр дээрх Орос, НАТО-ын ашиг сонирхол хийгээд байр сууриа илэрхийлэх илүү шинэ, ноцтой зөрчлийг гаргаж ирсэн явдал байлаа.

1.3. “Дахин ачаалсан” харилцаа (Reset) буюу Орос, Америкийн ойртох гурав дахь алхам (2009-2012)

АНУ-ын дэд ерөнхийлөгч Жо.Байдан 2009 оны 2-р сарын 7-нд болсон Мюнхений аюулгүй байдлын чуулга уулзалтын үеэр “ АНУ-ОХУ хоёр хоорондын харилцаанд ”reset” буюу “дахин ачаалах” товчлуур дээр дарах цаг болжээ”⁵ хэмээн мэдэгдсэнээр Орос-Америкийн хоорондын харилцааг сайжруулах үйл явц эхлэв. Энэ нь 6 сарын өмнөх Өмнөд Осетийн үйл явдлын шууд үр дагавар гэж үзэж болохоор байв. Тус “таван өдрийн” богино дайн Оросын хувьд маш том сорилт болж, шинэхэн түүхэн дэх хилийн гадна анх удаа зэвсэг хэрэглэсэн явдал байв. “Дахин ачаалах” харилцааны цаана орших обьектив шалтгаан нь: 1) зэвсгийн хяналтын дэглэм нурах аюул, 2) Орос, Америкийн цэргийн мөргөлдөөний аюулыг бууруулах, 3) ямар нөхцөлд Москва стратегийн зэвсгээ цөөрүүлэхийг Барак Обамагийн засгийн газар тодруулах зорилготой байв. “Дахин ачаалах” бодлогын эхний жил хагасын хугацаанд стратегийн давшилтын зэвсгийг хорогдуулах (СНВ-3) Прагын гэрээг байгуулж чадсан ба “Атомын эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах салбарт хамтран ажиллах

4 Выступление Президента РФ Владимира Путина на Мюнхеской конференции по вопросам политики безопасности 10 февраля 2007 года. / <http://izvestia.ru/news/321595#ixzz4VnWWwTeC>

5 Joe Biden. (Vice President of the United States 2009-2017). Remarks by the Vice President at the 45th Munich Conference on Security Policy. February 7, 2009. <http://www.presidency.ucsb.edu/ws/index.php?pid=123108>

тухай хэлэлцээр” байгуулахаар болов. Талууд Афганистаны талаар хамтын ажиллагаагаа өргөжүүлэн НАТО-ийн ачаа тээврийг дамжуулах тээвэр-логистикийн төвийг Ульяновскт хүртэл байгуулахаар болжээ. АНУ хуучин ЗХУ-ын орон зайд НАТО-г тэлэх болон Польш, Чехийн нутаг дэвсгэр дээр ПДХ систем байгуулах ажиллагаагаа хойшлуулав. Үүний үр дүнд Орос АНУ-тай Ираны цөмийн хөтөлбөрийн асуудлаар хамтран ажиллах, харин АНУ ТУХН-ийн орнууд, юуны өмнө Украины дотоод улс төрийн хэрэгт оролцох оролцоогоо бууруулав.

Гэвч 2010 оны дунд үеэс “дахин ачаалах” бодлого төдийлөн амжилттай үргэлжилсэнгүй. Учир нь Прагын гэрээ онцын ач холбогдолгүй цаас болж хувирсан ба ОХУ АНУ-ын Европ дахь ПДХ системээ татаж авах асуудлаар АНУ-тай зөвшилцөлд хүрч чадсангүй. Тийм учраас Оросын тал АНУ Европ тивд ПДХ систем барьж эхэлбэл Орос энэхүү гэрээг цуцлах эрхтэй хэмээсэн хавсралтыг Прагын гэрээнд нэмээд, түүн дээрээ өөрсдөө гарын үсэг зуржээ. 2010 оны 6-р сарын 24-нд болсон Вашингтоны чуулга уулзалтан дээр ерөнхийлөгч Д.Медведев, ерөнхийлөгч Б.Обама нар энэ асуудлаар тохиролцож чадаагүй ба хоёр орны төрийн тэргүүн нар баллистик пуужинг ажиглах салбарт хамтран ажиллах тухай хамтарсан мэдэгдлээр хязгаарлав. Энэ үед Орос-Америкийн харилцаанд зөрчил дагуулсан хэд хэдэн үйл явдлыг дурдаж болно. Үүнд:

- Европт тактикийн цөмийн зэвсгийг бууруулах хэлэлцээр эхлүүлэхийг Орос татгалзав.
- Ливи дэх НАТО-ийн ажиллагааны талаарх Оросын дургүйцэл;
- Сирийн асуудлаар Орос, Америкийн байр суурийн зөрөөтэй байдал;
- Төв Азид 2011 оны намраас хойш АНУ-ын бодлого идэвхижих болсон;
- 2012 оны “Магнитскийн хууль”, “Дима Яковлевын хууль” буюу “ОХУ-ын иргэний эрх, эрх чөлөө, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн этгээдэд авах арга хэмжээний тухай хууль”;
- “Бутагийн хэрэг” зэрэг хүмүүнлэгийн асуудлуудад талууд хэт санал зөрүүтэй байв.

Орос, Америк хоёр албан ёсны түвшинд хоёр орны харилцаанд хямрал байгааг үгүйсгэж байсан ч хоёр улсын засгийн газар ойлголцож чадалгүй үлджээ. Орос, Америкийн харилцаа ойртох нааштай алхам бүр хоёр талын харилцааны хурцадмал байдлыг дагуулж байв. Оросын хувьд хоёр орны харилцааг дахин ачаалах нь тийм ч гол биш бөгөөд харин Америктай зэрэгцэн дэлхийн нэг шийдвэрлэгч, нөлөө бүхий хүч болох, дэлхийн дэг журмын хүчний дахин хуваарилалтад байр сууриа бэхжүүлэх, олон улсын тавцан дээр өөрийн бие даасан бодлогыг хэрэгжүүлэх дэлхийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд улс төр, дипломатын арга хэрэгслээр идэвхтэй нөлөөлөх чадавхи бүхий субъект гэдгийг дэлхий дахинд хүлээн зөвшөөрүүлэхэд гол анхаарлаа хандуулж байв.

XXI зууны эхний арван жилийн сүүл гэхэд АНУ-д нийгмийн амьдралын бүх салбарыг хамарсан тогтолцооны хямралын шинж тэмгүүд илрэх болсоноор хэт их гүрэн хэмээгдсэн АНУ төвт дэлхийн нэг туйлт тогтолцооны нягтрал саармагжин, олон улсын тавцан дахь АНУ-ын нөлөө, нэр хүнд сулран, улмаар олон туйлт, олон төвт тогтолцоо бий болох хандлага эрс нэмэгдэв. Үүнд нөлөөлсөн хэд хэдэн хүчин зүйлүүдийг дурдаж болох бөгөөд тухайлбал, АНУ-ын санхүүгийн пирамид нуран унаснаар ДНБ эрс буурч, ажилгүйдэл өсөв. АНУ Ирак болон Афганистанд явуулсан дайнаар Талиб болон Саддам Хусейны дэглэмийг нурааж чадсан ч партизануудын эсрэг үргэлжилсэн олон жилийн сунжирсан дайнд 1 их наяд ам.долл. зарцуулсны улмаас улсын төсвийн хомсдол өсөх нэг шалтгаан болсон төдийгүй дэлхий дахины асуудалд тавих хяналтаа алдаж эхэлсэн. Үүний зэрэгцээ ОХУ хямралаас гарч, Хятад, Энэтхэг зэрэг орнуудын эдийн засаг эрчимтэй өсөх болов.

1.4. Орос, Америкийн “дахин ачаалах” харилцааны төгсгөл (2012-2013)

2013 оны эхээр талууд Орос, Америк хоёр орны хурцадмал байдлыг намжааж, харилцаа хамтын ажиллагааг сэргээх явдал зайлшгүй шаардлагатай гэсэн дүгнэлтэнд хүрэв. Учир нь цаашид сөргөлдөөн өсөн нэмэгдэх нь хоёр талын харилцааны үндэс болсон зэвсэг хураах гэрээнүүд бүрэн зогсоход хүргэх аюултай байв. Талуудын стратегийн яриа хэлэлцээг сэргээх эхний алхам бол цөмийн зэвсгийн

стратегийн давшилтын зэвсгийг хорогдуулах (СНВ-3) гэрээнд заасан түвшинээс 50%-иар бууруулах Пентагоны санал байв. Энэ нь 2020 оноос хойш Орос, Америк тус тус стратегийн 750-800 цэнэгтэй, 350-400 зөөгчтэй үлдэх тухай яриа байв. Стратегийн яриа хэлэлцээг сэргээх хоёр дахь оролдлого бол 2013 оны 6-р сарын 19-нд АНУ-ын ерөнхийлөгч Б.Обама Берлинд Стратегийн давшилтын зэвсгийн таазыг (СНВ-3) гэрээнд зааснаас гуравны нэгээр бууруулан, цөмийн цэнэгийн тоог 1000-аас доош болгох, түүний зэрэгцээ тактикийн цөмийн зэвсгийг хорогдуулах тухай хэлэлцээрээ дахин эхлүүлэхийг уриалав. Гэвч Оросын тал Цагаан Ордоны энэ саналыг хүлээж аваагүй нь Орост ашиггүйдээ бус цэргийн хүч чадлыг зохих түвшинд байлгах, стратегийн зэвсгийг тэнцвэрт түвшинд барихад илүү ач холбогдол өгсөнд байв. Оросын хувьд цөмийн зэвсгээ хадгалж үлдэх нь улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа болж байдаг.

Орос, Америкийн харилцааны “Дахин ачаалах” төлөвлөгөө бодит үр дүнд хүрээгүй нь америкчуудын өөрсдийн хэрэглэсэн нэр томъёо хоёр орны харилцааг ойртуулахад төдийлөн амжилт авчирч чадаагүй бөгөөд хамтран ажиллах хөрс суурь нь хангалттай тогтвортой бус байгааг харуулж байна. Хоёр орны хоорондын харилцааны хамгийн төвөгтэй асуудал бол итгэлцлийн түвшинд ажил хэрэгч, үр бүтээлтэй яриа хэлэлцээний талбарыг бий болгох явдал бөгөөд дэвшил, өөдрөг байдлын араас хурцадмал байдал, зөрчил, харилцан бие биеэ шүүмжлэх явдлыг үргэлж дагуулж байлаа.

2. Сөргөлдөөн дундах Орос, Америкийн хязгаарлагдмал түншлэл (2014-2017)

Дэлхийн их гүрнүүдийн геополитикийн ашиг сонирхлыг ил болгож асар богино хугацаанд олон улсын байдлыг хурцатгасан Украины хямрал, Ойрхи Дорнодын зөрчил, “Исламын улс” террорист бүлэглэл, дүрвэгсэдийн асуудал, Brexit зэрэг олон улсын байдал бүхий л талаар нөлөөлөхүйц үйл явдлууд дэлхий дахины хямралыг гүнзгийрүүлж, хүйтэн дайны уур амьсгалыг сэргэхэд хүчтэй нөлөөлж байгаагаас их гүрнүүдийг “шинэ хүйтэн дайн”-ы эхлэл рүү татан оруулах нөхцөл байдалд хүргээд байна. Энэ тухай 2016 оны 2-р сарын 12-14-нд чуулсан Мюнхены аюулгүй байдлын олон улсын хурал дээр ОХУ-ын Ерөнхий сайд Д.Медведев Орос, Барууны орнуудын

хоорондын харилцаа шинэ “хүйтэн дайн”-д хүрсэнийг ил тод хүлээн зөвшөөрөв. АНУ, Европын холбоо болон тэдний холбоотнууд Орос Крымыг нэгтгэсэнтэй холбогдуулан хоёр жилийн өмнө хориг тогтоосны дараагаас эхэлсэн хэмээн онцоллоо.

Барууны тэргүүлэх тинк танк төв болох Лондонгийн Стратегийн хүрээлэнгийн (IISS) шинжээчдийн тодорхойлж байгаагаар ХХ зууны 90-ээд оны эхэн үеэс тогтсон АНУ-ын дангаар ноёрхох манлайлал төгсгөл болж, өнөөгийн олон улсын харилцааны дэг журам өөрчлөгдөн олон туйлт болсон мэт боловч олон туйлт ертөнцөөс язгуураараа өөр байна. Дэлхийн шинэ тоглогчид аливаа сөргөлдөөнийг шийдвэрлэх эрх мэдлийг дангаар эзэмшихийг илүүд үзэж байна. Тухайлбал, Оросын Сири дэх үйл ажиллагаа, Хятадын Зүүн Өмнөд Хятадын тэнгис дэх түрэмгийлэл болон Йемен дэх Саудын Аравын халдан орсон байдал зэрэг бэлхнээ харуулж байна.

Сүүлийн жилүүдэд Путиний удирдлага доорхи Оросын хүч дахин сэргэж, олон улсын аюулгүй байдлын системд үзүүлж буй нөлөө, олон улсын тавцан дахь байр суурь нь идэвхжиж байна. Өнөөгийн Орос, Америкийн харилцаа нь түншлэл, сөргөлдөөн дундах тодорхой ашиг сонирхолд хөтлөгдсөн хязгаарлагдмал түншлэлийн шинжийг илүү агуулж байна.

2.1. Хоригоор хязгаарлагдсан Оро, Америкийн харилцаа

Орос Крымийг бүрэлдэхүүндээ авснаас хойш Орос, Америкийн төдийгүй олон улсын харилцаанд ихээхэн өөрчлөлт, шинэ нөхцөл байдлыг авчирлаа. Украины хямралыг Зөвлөлтийн дараах төрт улсын болон нэг туйлт ертөнцийн шинэ загварын тогтолцооны хямрал гэж нэрлэж болно.⁶ Украины хямрал эхнээсээ Украины дотоодын мөргөлдөөн, нөгөөтэйгүүр Орос, Америкийн хоорондын сөргөлдөөн гэсэн хоорондоо төдийлөн огтлолцохгүй хоёр талбараар өрнөж байна. Ямартаа ч нэг талаас олон улсын тавцанд Оросын нэр, нөлөөг эерэг болон сөрөг алин болсон ч өсөн нэмэгдүүлж, Оросыг дэлхийн нийтийн анхаарлын төвд авчирсан. Нөгөө талаас ОХУ ба АНУ, түүний холбоотонуудын хоорондын цэрэг зэвсэг, санхүү, эдийн засгийн өрсөлдөөн улам ил тод, хурц ширүүн болж, цаашид ч энэ

⁶ Украина: предпосылки кризиса и сценарии будущего. Доклад международного дискуссионного клуба “Валдай”. Москва. Сентябрь. 2014. Стр. 7.

байдал үргэлжлэх олон улсын харилцааны зангилаа цэг болов. Юуны өмнө Украины хямрал Орос, Америкийн ашиг сонирхлын зөрчил тэмцэл хүйтэн дайны үеэс ч дутахааргүй хүчтэй хэвээрээ гэдгийг харуулж байна. АНУ Москваг Крымын төлөвлөгөөг Донецк мужид хэрэгжүүлэхийг оролдож буй хэмээн буруушааж байгаа бол Орос улс АНУ болон НАТО-ын зүгээс Оросыг бүслэх гэсэн оролдлого хэмээн үзэж байна. Учир нь Украин ЕХ болон НАТО-ын гишүүнээр элсэхээр төлөвлөсөн явдал Оросын ашиг сонирхолтой зөрчилдсөн. 2016 оны 1-р сарын 1-ээс ЕХ, Украины хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулагдаад байна.

АНУ-ын зүгээс хориг тавьж, удалгүй ЕХ ч хориг арга хэмжээ авах болсон нь “Хүйтэн дайн” дууссанаас хойш их гүрнүүдийн хоорондын мөргөлдөөны эхлэлийг тавьсан. Америкийн хоригийн арга хэмжээний зорилго бол Оросын улс төрийн шийдвэрийг өөрчлөхөд чиглэж байгаа боловч, Москва тус хоригийг Оросын улс төрийн дэглэмийг нураах гэсэн оролдлого хэмээн үзэж байна.⁷

АНУ болон бусад холбоотон орнууд энэхүү үйл явцыг Украины бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолд ОХУ заналхийлсэн алхам гэж үзэн 2014 оны 3-р сараас өнөөг хүртэл 3 жилийн турш үргэлжилж буй хоригийн давалгаа Оросын өндөр дээд албан тушаалтан болон хуулийн этгээдийн хөлийг хорьсон салбарчилсан нэрсийн жагсаалтаар эхэлж байсан бол өнөөдөр эдийн засгийн салбар төдийгүй мэдээлэл, харилцаа, холбоо, зэвсэг техникийн чиглэлийг хамрах болов. Тухайлбал, шат дараалсан хоригийн арга хэмжээний хүрээнд банкны салбарын Оросын 5 том банк болох “Сбербанк России”, “ВТБ” банк, “Газпромбанк”, “Внешэкономбанк”, “Россельхозбанк”, нефть-хийн секторт Оросын түлш, эрчим хүчний томоохон компаниуд болох “Газпром”, “Лукойл”, “Транснефть”, “Газпром нефть”, “Сургутнефть”, “Новатэк”, “Роснефть”, батлах хамгаалах, аж үйлдвэрийн салбарт 3 тэргүүлэх компани болох “Уралвагонзавод”, “Оборонпром”, “ОАК” болон бусад батлах хамгаалах чиглэлийн 9 концерн, хэвлэл мэдээллийн салбарт “Газпром-медиа” холдингийн эзэмшдэг НТВ, ТНТ, “Матч ТВ”, “2x2 телевизийн сувгууд багтаад байна. Тодорхой салбаруудад

⁷ Mark Leonard. Geopolitics vs Globalization: How Companies and States Can Become Winners in the Age of Geo-economics.// Geo-economics Seven Challenges to Globalization. P.5

чиглэсэн хоригийн арга хэмжээнээс харахад АНУ Оросыг олон улсын тавцанд ганцаардуулах, тусгаарлах, сулруулах бодлого баримталж байгаа нь илэрхий байна.

АНУ-ын өмнөх ерөнхийлөгч Б.Обамагийн Засгийн газрын үед Орос, Америкийн хооронд үүсээд байсан үл ойлголцол улам гүнзгийрч, хоёр орны хооронд байгуулсан хэд хэдэн гэрээг хүчингүй болгосноор Орос-Америкийн харилцаа улам хүйтэн болсон.

Д.Трамп АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсоноор хүйтэн дайнаас хойш доод түвшиндээ хүрээд буй Орос, Америкийн харилцаа сайжран, улмаар Оросын эсрэг хоригийг цуцлах, Кремльтэй Сирийн мөргөлдөөнд хамтран ажиллах, Крым Оросод нэгдсэнийг хүлээн зөвшөөрөх зэрэг асуудлыг яриа хэлэлцээний замаар шийдвэрлэнэ хэмээн олон удаа илэрхийлж байсан ч түүний үг үйлдэл хоёр зөрж байна. Харин ч тэрээр Орос, Америкийн харилцааг муутгах олон алхам хийж байгаагийн дээр Оросын эсрэг авах хоригийн арга хэмжээг улам чангатган өргөтгөсөөр байна.

АНУ 2017 оны 6-р сарын 20-нд Оросын эсрэг хориг арга хэмжээний жагсаалтыг 19 байгууллага, 19 хүнээр өргөтгөсөн бол ЕХ 2017 оны 6-р сарын 28-нд эдийн засгийн хоригийг хагас жилээр сунгасан байна. ОХУ хариуд нь хөдөө аж ахуй болон хүнсний бүтээгдэхүүнийн импортод тавьсан хоригоо 2018 оны 1-р сар хүртэл сунгаад байсан бол 6-р сарын 30-нд 2018 оны 12-р сарын 31-ыг хүртэл сунгав.

Түүнчлэн АНУ-ын зүгээс Оросын эсрэг авах хориг арга хэмжээг өргөжүүлэх тухай хуулийн төслийг батлах болсон ба уг хуулийн төсөлд Иранд үзүүлэх шахалтыг хүчтэй болгох, мөн БНАСАУ-ын эсрэг шинэ хоригийг оруулсан байна. Уг хуулийн төсөлтэй холбогдуулан 2017 оны 7-р сарын 28-нд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин ОХУ дахь АНУ-ын дипломатуудын тоог 9-р сарын 1-н гэхэд 755-аар цөөлж 455 болгохоор шийдвэрлэсэн.

Оросын Эдийн засгийн шинжээчдийн бүлгийн мэдээлж байгаагаар хориг тогтоосноос хойшхи өнгөрсөн 3 жилийн хугацаанд Оросын эдийн засаг банк, санхүү, нефтийн үнийн уналт гэсэн давхар цохилтын улмаас 600 тэрбум ам.долларын хохирол амссанаа хүлээн

зөвшөөрөөд байна.⁸ Оросын эдийн засаг түүхий эдийн экспортоос хэт хамааралтай байсаар ирсэн нь нефтийн салбар дахь хоригт цохигдох нэг хүчин зүйл болов. 2013 онд нэг баррель нефтийн үнэ 110 ам.долл. байсан бол дэлхийн зах зээл дээрх нефтийн үнэ унаснаар 2014 оны сүүл гэхэд 98 ам.долл. болж, өнөөдөр 50 ам.доллар⁹ хүртлээ буураад байна. Ийнхүү рублийн ханш болон газрын тосны үнийн уналттай хамт Оросын эдийн засгийг ганхуулаад зогсохгүй рублийн ханшийн уналт нь бүс нутгийн валютын ханшийн тэнцвэртэй байдал алдагдахад хүргэх магадлалтай юм.

Крымиг өөртөө нэгтгэснээр В.Путины улс орон доторх нэр нөлөөг өсгөж, тус улсад эх оронч, үндэсний үзэл сэргэсэн нь удаан хугацаанд улс орны тогтвортой байдлын баталгаа болох магадлалтай. Хоригийн арга хэмжээг эдийн засгийн ашигтай нөхцөл, давуу байдал болгохыг оролдож, Оросын эдийн засгийн бүтцийг өөрчлөн импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломж гэж харж байна. Гэвч 2017 оны эхний байдлаас харахад импортыг орлох бүтээгдэхүүн хүн амын хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгаагийн дээр хэдийгээр үйлдвэрлэгчид бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хэд дахин нэмэгдүүлээд байгаа ч бодит байдал дээр хүссэн үр дүнд хүрэх хүчин чадал дутмаг байна.

Оросын ГХЯ-ны сайд С.Лавров ЕХ-ны орнууд АНУ-ын дарамт шахалтын дор ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээг авч байна гэж мэдэгдсэн бол Орост суугаа Европын бизнесын Холбооны дарга Франк Шауфф Америкчууд Оросын хоригийн арга хэмжээ авах талаар Европчуудад ихээхэн дарамт шахалт үзүүлсэн. Америкийн гадаад худалдаанд Оросын худалдаа ердөө 3,7%-ийг эзэлдэг учраас Америкийн эдийн засагт хоригийн асуудал ямар ч нөлөө үзүүлэхгүй байгаа юм гэжээ. ЕХ-ы орнуудын хувьд эдийн засгийн хориг арга хэмжээ хоёр талдаа иртэй хутга мэт нөлөөлж, Оростой хийх ЕХ-ы гадаад худалдаа 7 дахин буурсан бол Орос, Америкийн хоорондох гадаад худалдаа ердөө 6%-иар буурчээ.

Хоригийн үр дүнд Оросууд АНУ-тай цөмийн зэвсгийн аюулыг бууруулахад хамтран ажиллахаас татгалзав. Ингэснээр цөмийн аюул дэгдэх эрсдэл өндөр боллоо.

⁸ <http://www.rbc.ru/economics/05/02/2016/56b3d9ef9a7947158745d497>

⁹ <http://politrussia.com/world/laquo-diplomatiya-prinuzhdeniya-ssha-226/>

Олон улсын харилцааны Европын зөвлөлийн захирал, улс төр судлаач, олон улсын харилцааны мэргэжилтэн Марк Леонард: “Хоригийн арга хэмжээ илүү нарийн төвөгтэй асуудал юм. Хачирхалтай нь, жинхэнэ ялагч гуравдагч этгээд болох тохиолдол байдаг. Тухайлбал, АНУ-Ираны хоригт Европын орнууд, Оросын эсрэг авсан Барууны хоригт Хятад, Тяньанмэний дараах Хятадын эсрэг авсан зэвсгийн хоригт Орос, ЕХ-ны Орост үзүүлсэн дарамтын улмаас Орос “Өмнөд урсгал” хийн хоолойн төслөөс татгалзах үед Турк хожиж байна.” гэжээ.

2.2. Орос, Америкийн харилцааны хэтийн төлөв

Орос, Америкийн хооронд сайн харилцаа тогтооно гэдэг төвөгтэй асуудал бөгөөд Оросын ашиг сонирхолыг тооцохгүй, түншлэгчийн хувиар харьцахгүй байгаа тохиолдолд хамтран ажиллах бодит үндэслэлийг бий болгож чадахгүй юм. Хоёр орны хооронд бараа эргэлт хамгийн бага, хөрөнгө оруулалтын томоохон төслүүд байхгүй. Харилцаа муудлаа гэхэд түүнд санаа зовох лобби бүлэг ч байхгүй. Тиймээс харилцааг сайжруулах биш, түүнийг үр ашигтай, тааварлаж болохуйц, эрх ашигаа харилцан харгалзсан болгохыг хичээх нь хоёр талын бодит зорилт юм. Украин, Сирийг тойрсон асуудлаар Орос, Америкийн хоорондын байр суурийн зөрчилтэй байдал харилцааг улам хурцатгав.

Оросын ерөнхийлөгч В.Путины 2016 оны 12-р сарын 1-нд шинэчлэн баталсан Гадаад бодлогын үзэл баримтлалд анх удаа Сирийн тухай оруулсан бөгөөд “Орос улс Сирийн Арабын Бүгд найрамдах улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, эв нэгдлийг дэмжиж байна”¹⁰ гэжээ. Кремль 2012 оны 6-р сарын 30-ны Женевын коммюникений дагуу Сирийн мөргөлдөөнийг зохицуулах олон улсын үйл ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагатай гэж үзэв. Евро-Атлантын бүс нутагт сүүлийн 25 жил хуримтлагдсан аюулгүй байдлын асуудлуудыг НАТО болон ЕХ шийдвэрлэж чадаагүй. АНУ болон түүний холбоотнууд Оросыг тогтоон барих, түүнийг улс төр, эдийн засаг, мэдээллийн болон бусад дарамт шахалт үзүүлснээр бүс нутгийн болон дэлхий нийтийн тогтвортой байдлыг сулруулж, улс түмний ашиг сонирхолд хохирол учруулж байна¹¹ гэжээ. Ийнхүү шинэ

10 http://www.mid.ru/foreign_policy/news/-/asset_publisher/cKNonkJE02Bw/content/id/2542248

11 http://www.mid.ru/foreign_policy/news/-/asset_publisher/cKNonkJE02Bw/content/id/2556212

үзэл баримтлалд анх удаа Орос, Америкийн харилцааг түншлэлийн бүс хязгаарлагдмал харилцаа болохыг тодорхойлов.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин дэлхий дахинд болон дотоодод гарч буй өөрчлөлт, түүнд эерэг болон сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг эргэж харах, дэлхийн хамтын нийгэмлэгт Оросын эзлэх байр суурь, олон улсын хэмжээний зөрчилдөөнийг зохицуулахад гүйцэтгэх үүргээ нэмэгдүүлэх шаардлага гарсантай уялдуулан үндэсний аюулгүй байдлаа хангах, гадаад бодлогын тулгуур зарчим, арга хэлбэрийг тодорхойлдог үндсэн баримт бичгүүдийг шинэчлэн батлав. Тухайлбал: 2014 оны 12-р сарын 26-нд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины шинэчлэн баталсан “Цэргийн номлол”, 2015 оны 12-р сарын 31-нд баталсан ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратеги, 2016 оны 12-р сарын 1-нд Гадаад бодлогын үзэл баримтлалаа шинэчлэн батлав.

ОХУ-ын ерөнхийлөгч В.Путины 2015 оны 12-р сарын 31-нд баталсан ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегид НАТО олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчин, эвслийн цэргийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, зүүн тийш тэлж, Оросын хил орчмын цэргийн дэд бүтцэд ойртох явдал бол үндэсний аюулгүй байдалд учруулж буй аюул занал¹² хэмээн тодорхойлсон. АНУ-ын пуужингийн довтолгооноос хамгаалах системийг Европ, Ази Номхон далайн бүс нутаг, Ойрхи Дорнодод байрлуулсан тохиолдолд дэлхий дахины болон бүс нутгийн тогтвортой байдлыг хангах боломж ихээхэн буурч байна. Түүнчлэн Украины үндсэн хуулийн эсрэг төрийн эргэлтийг АНУ болон ЕХ дэмжсэний уршгаар Украины нийгэмд гүн хагарал гарч, зэвсэгт мөргөлдөөнд хүргэснийг буруушаагаад Украины нийгэм-эдийн засгийн гүн хямрал нь Европт болон Оросын хилийн дэргэд урт хугацааны тогтворгүй байдлын голомтыг бий болгож байна¹³ гэжээ.

2014 оны 12-р сарын 26-нд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины шинэчлэн баталсан “Цэргийн номлол”-ыг өөрчлөх болсон үндсэн шалтгаан нь Москва, Вашингтон, Брюсселийн хоорондын харилцаа өмнөхтэйгөө адилгүй болж, НАТО-гийн зүгээс зүүн тийш тэлэх стратегийн давшилтын чадавхиа нэмэгдүүлж, АНУ-ын ПДХ системийг

¹² Стратегия национальной безопасности Российской Федерации. <https://rg.ru/2015/12/31/nac-bezopasnost-site-dok.html>

¹³ Стратегия национальной безопасности Российской Федерации. <https://rg.ru/2015/12/31/nac-bezopasnost-site-dok.html>

Польш болон Румыны нутаг дэвсгэр дээр байрлуулж, Оросын баруун хилд тулсан зэрэг үндэсний аюулгүй байдалд заналхийлэх үйлдлүүд илэрхий нэмэгдэх болсонтой холбоотой.

ОХУ-ын хил дээр хүнд зэвсгүүд байрлуулж байгаа явдал Вашингтоны хүйтэн дайнаас хойшхи Пентагон, НАТО-гийн хамгийн түрэмгий үйлдэл хэмээн ОХУ-ын Батлан хамгаалах яамны нарийн бичгийн дарга Ю.Ябуков мэдэгдсэн. АНУ энэхүү үйлдлээ эдгээр Зүүн Европын орнуудад ээлжлэн цэргийн сургуулилт хийх төдийгөөр тайлбарлаж байгаа ч үнэндээ байнгын цэргийн бааз байгуулах зорилготой. Энэ үйлдэл нь 1997 оны Орос-НАТО-ийн харилцааны үндсэн бичигт баримтанд заасан “НАТО эдгээр орнуудад байнгын цэргийн хүчин байрлуулахгүй гэсэн амлалтаас няцаж байгаа юм. ОХУ-ын зүгээс холбогдох орнууд асуудалд зөвөөр хандаж, Европын байдал цэргийн сөргөлдөөн рүү орж шилжихээс зайлсхийн, ноцтой үр дагаварт хүрэхээс сэргийлэхийг уриалж байна. Гэвч Зүүн Европ болон Балтын тэнгисийн орнууд АНУ-ын шийдвэрийг хүлээн авахаар бол Орос улс барууны стратегид өөрийн хүч, нөөц бололцоог ашиглахаас өөр сонголтгүй болно.

2016 оны 9-р сарын 23-нд ОХУ-ын ГХ-ийн сайд С.Лавров НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 71-р чуулганы индэр дээрээс Орос-Америкийн харилцаанд хоёр орны хоорондын ашиг сонирхлын тэнцвэрт байдлын тулгуур болсон хоёр орны эрх баригчдын хоорондын харилцаа ихээхэн нөлөөтэй байдгийг онцлоод, магадгүй Америкийн шинэ засаг захиргаа үндэсний ашиг сонирхолоо хэрхэн ойлгохоос бүх зүйл шалтгаалах болно гэв. Энд дурдсанаар хоёр орны харилцаа шинэ түвшинд хүрнэ гэж найдаж байгаагийн зэрэгцээ олон улсын асуудалд хандахдаа Америкийн шинэ засаг, захиргаа Б.Обамагийнхаас илүү тодорхой байр суурийг баримтлан АНУ, ОХУ болон бусад хамтын нийгэмлэгүүдийн ашиг сонирхлыг харилцан хүндэлсэн, эн тэнцүү зарчим дээр тулгуурласан үр дүнтэй яриа хэлэлцээрүүдийг хийнэ гэж итгэж байгаагаа илэрхийлсэн.

2017 оны 7-р сарын 7-нд Германы Гамбург хотноо болсон “Их 20”-ийн уулзалтын үеэр АНУ-ын ерөнхийлөгч Д.Трамп, ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин нарын анхны нүүр тулсан уулзалтын үеэр Д.Трамп хоёр орны ашиг сонирхлын тэнцвэрийг хадгалахын тулд

ажиллах болно хэмээн мэдэгдсэн ч ойрын ирээдүйд нөхцөл байдал өөрчлөгдөхгүй болох нь харагдлаа хэмээн ОХУ-ын ГХ-ийн сайд С.Лавров сэтгүүлчдэд өгсөн ярилцлагадаа дүгнэн хэлсэн нь Трампын Засгийн газрын үеийн Орос-Америкийн харилцааны ирээдүй, хэтийн төлөв байдлыг хүйтэн дайны үеийн болон түүнээс хойших үеийн хэмжүүрээр биш өнөөгийн зах зээлийн нийгмийн үеийн өрсөлдөгчийн байр суурийн үүднээс харах шаардлагатай болж байгаа нь харагдаж байна.

Орос, Америкийн хоорондын харилцааны хамгийн төвөгтэй асуудал бол итгэлцлийн түвшинд ажил хэрэгч, үр бүтээлтэй яриа хэлэлцээний талбарыг бий болгох явдал бөгөөд дэвшил, өөдрөг байдлын араас хурцадмал байдал, зөрчил, харилцан бие биеэ шүүмжлэх явдлыг үргэлж дагуулж байлаа.

Сүүлийн жилүүдэд Путиний удирдлага доорхи Оросын хүч дахин сэргэж, олон улсын аюулгүй байдлын системд үзүүлж буй нөлөө, олон улсын тавцан дахь байр суурь нь нэмэгдэх болсон ч АНУ болон Барууны орнуудын зүгээс Оросыг дайсагнагч улс хэмээн үзэх хандлага улам нэмэгдэж байна. Энэ талаар ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин сэтгүүлчдэд өгсөн ярилцлагадаа “АНУ-д НАТО болон Европын талаар баримталж буй бодлогоо хэрэгжүүлэх, цэргийн эвслийг тогтоон барьж байхын тулд Оросыг дайснаа гэж үзэх хангалттай шалтгаан бий” гэж хэлсэн байна. Өнөөгийн Орос, Америкийн харилцаа нь түншлэл, сөргөлдөөн дундах тодорхой ашиг сонирхолд хөтлөгдсөн хязгаарлагдмал түншлэлийн шинжийг илүү агуулж байна.